

**САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2008 оны 10 дугаар
сарын 31-ны өдөр

Дугаар 356

Улаанбаатар
хот

Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох
Сонгон шалгаруулалтын удирдамж батлах тухай

Хөрөнгийн үнэлгээний талаар авах зарим арга хэмжээний тухай Сангийн сайдын 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 339 тоот тушаалыг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл олгох Сонгон шалгаруулалтын удирдамжийг хавсралтаар баталсугай.
2. Энэ удирдамжийн дагуу хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулахыг Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 271 дүгээр тушаалаар батлагдсан Сонгон шалгаруулалтын хороо /Ж.Үхэртар/-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Д.БАТТӨР

Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны
10 дугаар сар 31 өдрийн 356 тоот тушаалын хавсралт.

ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХОРООНЫ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү удирдамжийн зорилго нь Сангийн сайдын 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 339 тоот тушаалын дагуу иргэнийг сонгон шалгаруулж хөрөнгийн үнэлгээний чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Үнэлгээчинг сонгон шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд (цаашид “үнэлгээчинг сонгон шалгаруулах ” гэх) аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, энэхүү баримт бичгийг удирдлага болгоно.
- 1.3. Үнэлгээчинг сонгон шалгаруулж, тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд ил тод байх, хууль дээдлэх, хараат бус байх, шударгадүүлэх зарчмыг баримтална.

Хоёр. Үнэлгээчнээр шалгуулагчдад тавигдах шаардлага, түүний бүртгэл

- 2.1. Сонгон шалгаруулалтад оролцох иргэнд тавигдах шаардлага:
 - 2.1.1. эрүүгийн ял шийтгэлгүй байх;
 - 2.1.2. Инженер, эдийн засаг, эрхч бизнесийн болон санхүүгийн удирдлагын аль нэгээр бакалавруунээс дээш боловсролтой, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
 - 2.1.3. хөрөнгийн үнэлгээний батлагдсан жишиг хөтөлбөрийн дагуу эрх бүхий байгууллагаас явуулсан сургалтанд хамрагдсан байх;
- 2.2. Шалгуулагч нь сонгон шалгаруулалтанд өрсөлдөө хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын хороонд /цаашид “хороо” гэх/ гаргана.
- 2.3. Хороо нь шалгуулагчийг тэгэхдээ энэ журмын 2.1 -д заасан шаардлагыг хангасан 2.4-т заасан баримтуудыг бүрдүүлсэн эсэхийг шалгаж бүртгэнэ.
- 2.4. Сонгон шалгаруулалтад оролцох шалгуулагч нь дараах материалыг бүрдүүлнэ:

- 2.4.1. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл-анкет **(Хүнэгт 1)**
 - 2.4.2. Ажлын газрын тодорхойлолт, эсвэл хамт ажиллаж байгаа буюу ажиллаж байсан 2-оос доошгүй мэргэжилтний тодорхойлолт;
 - 2.4.3. Их, дээд сургууль төгссөн тухай диплом, гэрчилгээний эх хувь хуулбарын хамт ;
 - 2.4.4. Нийгмийн даатгалын дэвтэр, түүний хуулбар;
 - 2.4.5. Үнэлгээний сургалтын жишиг хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан 94 цагийн сургалт, эсвэл түүнтэй жишиж болох сургалтын сертификат;
 - 2.4.6. Бүртгэлийн хураамж ;
 - 2.4.7. Иргэний үнэмлэх, гадаадын иргэний хувьд түүнийг хэн болохыг нотолсон адилтгах бусад бичиг баримт, түүний хуулбар ;
 - 2.4.8. Ял шийтгэлтэй эсэх талаар цагдаагийн байгууллагын тодорхойлолт;
 - 2.4.9. Бусад шаардлагатай гэж үзсэн материалуудыг нэр дэвшигч өөрөө хавсарган ирүүлж болно.
- 2.5. Шалгуулагч нь гадаадын иргэн бол монгол хэлээр шалгаруулалтанд оролцох бөгөөд орчуулагчийн зардлыг өөрөө хариуцна.

Гурав. Үнэлгээний тусгай зөвшөөрөл олгож, сонгон шалгаруулах ажиллагаа

- 3.1. Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтанд энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан Монгол Улсын болон гадаадын иргэн нэрээ дэвшүүлэх эрхтэй.
- 3.2. Хороо нь үнэлгээний тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын товыг (шалгуулагчдад тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт явуулах газар, болон холбогдох бусад мэдээллийн хамт) үндэсний олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр шалгалтаас 60 хоногийн өмнө зарлана.
- 3.3. Үнэлгээний тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа нь гурван үе шаттай явагдана. Нэгдүгээр үе шат шалгуулагчийн бүрдүүлэх баримт материалыг хянаж үзэх, хоёрдугаар үе шат бичгийн шалгалт, гуравдугаар үе шат ярилцлага байна.
 - 3.3.1. Шалгалтын оноо: Нэгдүгээр үе шатанд шалгуулагчийн сонгон шалгаруулалтад тавигдах шаардлагад нийцүүлж бүртгүүлсэн бичиг баримтын бүрдлийг үнэлж 10 оноо өгнө. Хоёрдугаар үе шатанд хууль эрх зүйн мэдлэг, үнэлгээний онол, стандарт, аргачлал, үнэлгээний тайлан, мэргэжлийн ёс зүй гэсэн чиглэлээр бичгийн шалгалт авч 60 оноо өгнө. Гуравдугаар үе шатанд хоёрдугаар үе шатны шалгалтын агууллагын хүрээнд ярилцлага хийж 30 оноо өгнө.
 - 3.3.2. Шалгалтын хугацаа: Бичгийн шалгалтыг 2,5 цаг, ярилцлагыг хүн бүрт 15 минутаар тооцно.

- 3.3.3. Нэгдүгээр шалгалтын дүнг хорооны гишүүдийн 75-аас дээш хувийн дундаж үнэлгээгээр гаргах ба 7,5-аас доош оноо авсан шалгуулагч дараагийн шалгалтад орох эрхгүй.
- 3.3.4. Хоёрдугаар үе шатны шалгалтыг сорилго хэлбэрээр карт бөглүүлэн авч, түүнийг карт шалгах машинаар засаж дүнг бүх шалгуулагчдын өмнө ил тод мэдээлнэ. Энэ үе шатны шалгалтын нийт онооны 75-аас доош оноо авсан шалгуулагч дараагийн шалгалтад орох эрхгүй.
- 3.3.5. Шалгуулагч бичгийн шалгалтад 45 түүнээс дээш оноо авсан бол шалгалт өгсөн өдөрөөс хойш 12 сарын хугацаанд хүчинтэй байна.
- 3.3. Ярилцлагын шалгалт нь шалгуулагч үнэлгээний үйл ажиллагаатай холбогдох хууль, стандарт, ёс зүй, арга зүй талаарх мэдлэг, чадварыг үнэлж дүгнэнэ. Энэ үе шатны шалгалтад 22.5-аас доош оноо авсан шалгуулагч шалгалтад тэнцээгүйд тооцно.
- 3.4. Сонгон шалгаруулалтын үнэлгээг ярилцлагын дараа гаргаж бүх нэр дэвшигчдэд танилцуулна. Хорооны үнэлгээгээр авбал зохих нийт оноо (100) - ны 75 ба үүнээс дээш оноо авсан шалгуулагчийг сонгон шалгаруултанд тэнцсэн гэж үзнэ. **(Хүснэгт 2)**

Дөрөв. Шалгалтын материал бэлтгэх зохион байгуулалт

- 4.1. Шалгалтын мэдээллийн санг бэлтгэх комиссыг мэргэжлийн багш, эрдэмтэн, туршлагатай үнэлгээчдийг н үрэлдэхүүнтэйгээр Хорооны даргын шийдвэрээр томилно.
- 4.2. Шалгалтын мэдээллийн сан үлнхөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн холбоотой хууль, эрх зүй, ёс зүйн мэдлэг, онол, стандарт, аргачлалын асуудлыг хамарсан байна
- 4.3. Комисс шалгалтын мэдээллийн санг 2-3 хувилбартай бэлтгэнэ. Комиссын гишүүд шалгалтын асуулт түүний хариуг тус тусд нь битүүмжилж, гарын үсэг зурсны дараа Сонгон шалгаруулалтын хорооны нарийн бичгийн даргад хүлээлгэж өгнө. Шалгалтын материалын үнэн зөв байдлыг мэдээллийн санг бэлтгэх комисс хариуцна.
- 4.4. Бичгийн шалгалт эхлэх өдөр битүүмжилсэн мэдээллээс сонголт хийж, хөрөнгийн үнэлгээний шалгалт авах материалыг бэлтгэх ажлыг зохион байгуулна.
- 4.5. Шалгалтын материалын нууцлалыг Хорооны дарга, шалгалтын материал бэлтгэсэн комиссын гишүүн хариуцана.

Тав . Үнэлгээчний эрх олгох ажлын зохион байгуулалт

- 5.1. Үнэлгээчинд тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулах үйл ажиллагааг хороо эрхлэн гүйцэтгэж дараах ажиллагааг явуулна:
- 5.1.1. үнэлгээний сонгон шалгаруулалтад тавигдах шаардлагын шалгуурыг боловсруулж, мөрдүүлэх;

- 5.1.2. үнэлгээний хороо үнэлгээчинг сонгон шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох удирдамжийн төслийг боловсруулж, батлуулж, мөрдөх ;
- 5.1.3. үнэлгээчний эрхийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох үндэслэлийг тогтоох;
- 5.1.4. үнэлгээчдийн бүртгэл хөтлөн, нийтэд нээлттэй байлгах;
- 5.1.5. Үнэлгээний шалгалт авахтай холбоотой ажлын хөлсний үнэлгээг тогтоох.
- 5.2. Хороо нь үнэлгээчдэд зориулсан сургалтын төлбөрийг батлах, сургалт явуулах хуулийн этгээд, иргэнийг сонгож, сургалт явуулахад нь дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааг хянах үүрэгтэй.
- 5.3. Өндөр мэргэшил, ур чадвартай мэргэжилтнүүдээр үнэлгээчдийн эгнээг өргөжүүлэх, нэрсийн жагсаалтыг баяжуулах зорилгоор үнэлгээчдийн сонгон шалгаруулалтыг жилд нэг удаа явуулна.
- 5.4. Хорооны үрэлдэхүүн нь төрийн захиргааны төв байгууллагууд болон үнэлгээний мэргэжлийн эрдэмтэн, багш, судлаачид үнэлгээний мэргэжлийн төрийн бус байгууллагын (мэргэжлийн нийгэмлэг) төлөөлөлтэй байна. Хороог төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөгч ахлана.
- 5.5. Хороо сонгон шалгаруулалтын нууцыг хадгалж, үний төлөө хариуцлага хүлээнэ.
- 5.6. Үнэлгээчдийн нэрсийн жагсаалтыг нийтэд байнга нээлттэй, хуулбарлан авах боломжтой байлгана.
- 5.7. Шалгалтын материал, хорооны гүүдийн хурлын шийдвэрийг 1 жил хадгална.

Тав. Бусад зүйл

- 6.1. Хөрөнгийн үнэлгээний сонгон шалгаруулалтын маргааныг хорооны гишүүдийн хуралаар хэлэлцэж эцэслэн шийдвэрлэнэ.
- 6.2. Хорооны саналыг үндэслэн үнэлгээчний тусгай зөвшөөрлийн эрхийг санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 3 (гурван) жилийн хугацаатай олгоно.
- 6.3. Үнэлгээний тусгай зөвшөөрлийн эрх авсан иргэнд батлагдсан загвараар гэрчилгээ олгоно.
- 6.4. Үнэлгээчний тусгай зөвшөөрлийн эрх авсан, эрхийн хугацаа дууссан, эрх нь түтгэлзсэн болон хүчингүй болсон тухай мэдээллийг хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн эрх олгосон төрийн захиргааны төв байгууллага нийтэд ил тод мэдээлнэ.

ӨРГӨДӨЛ-АНКЕТ

ХҮСНЭГТ 1.

ЗУРАГ

Овог нэр	
Хаяг: (Харилцах утас, e-мэйл хаягийг бичнэ)	
Төрсөн он, сар, өдөр Паспортын дугаар, регистр	
Одоо эрхэлж буй ажил	
Боловсрол, сургалтанд хамрагдсан байдал (сургуулийн нэр, сурч төгссөн он сар, өдрийг зааж, диплом, гэрчилгээний хуулбарыг хавсаргана)	
Мэргэжлийн дадлага туршлага (ажиллаж байсан салбар, эрхэлж байсан албан тушаал, он сар, өдрийг бичнэ) (холбогдох баримтуудыг хавсаргана)	
Үнэлгээний ажиллагаатай холбоотой дадлага туршлага (холбогдох баримт бичгийг хавсаргана)	
Нийгэмд үнэлэгдэх байдал (Ажлын газрын эсвэл хамт ажиллаж байсан 2-оос доошгүй мэргэжилтний тодорхойлолт)	
Ял шийтгэлтэй эсэх (Эрх ёхий байгууллагын тодорхойлолт, жижиг авто осол орохгүй)	
Өөр төрлийн тусгай зөвшөөрөл эзэмшдэг эсэх	
Шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл	

**ҮНЭЛГЭЭЧНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД ОРСОН ШАЛГУУЛАГЧИД
ӨГСӨН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДҮГНЭЛТ**

Шалгуулагчийн овог нэр:

Нас:

Хаяг , холбоо барих утас:

Шалгуур		Авсан оноо
<i>Нэгдүгээр үе шат:</i>		
1	Боловсрол, мэргэжил	
2	Тухайн мэргэжлийн салбарт ажилласан дадлага, туршлага	
3	Үнэлгээний чиглэлээр ажилласан туршлага	
	А. Суурь оноо (10)	
<i>Хоёрдугаар үе шат</i>		
	Б. Бичгийн шалгалт (60 оноо)	
<i>Гуравдугаар үе шат</i>		
	В. Ярилцлага, тайлан хамгаалалт (30 оноо)	
	<i>Эцсийн үнэлгээ (100 хүртэл оноо, /А+Б+В/:3)</i>	

Огноо-----

Эцсийн үнэлгээг баталсан:

Үнэлгээний хорооны дүгнэлт:

Үнэлгээний хорооны дарга

Үнэлгээний хорооны гишүүн: